

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 01 дугаар сарын 08 -ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Сумдын мал эмнэлгийн тасгийн
шуурхай ажил үйлчилгээнд
мотоцикл худалдан авах тендер

Тендер шалгаруулалтын дугаар: **МЭТШ/2019/01-003**

Мал эмнэлгийн ерөнхий газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос 331 ширхэг Мал эмнэлгийн тасгуудын мотоцикл худалдан авах тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр иж бүрдлээр нь **50,000 /Тавин мянга/** төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **[30]** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2018, 2019 оны аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт оролцогчийн санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт оролцогчийн санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас дээш байх тухай нотлох баримтыг ирүүлнэ.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2 жил буюу 2018, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлнэ.

Тендерийн хамт тендерт оролцогч өөрийн санал болгож буй тендерийн үнийн 1 хувьтай тэнцэх төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 14 цаг 00 минутаас өмнө **tender.gov.mn** хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 14 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хаяг: Мал эмнэлгийн ерөнхий газар,
14 тоот, Засгийн газрын 9 дүгээр байр,
Энхтайвны өргөн чөлөө-16/Б, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар-13381, Монгол улс
Утас: 976-51-261639; Факс: 976-51-261635**